



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 4 сарын 1 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар, төсвийн зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Ажлын хэсгийн тайлан, удирдамжийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

132013924

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 7 дугаар сарын 7 өдрийн
А/2024 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН
/ХӨВСГӨЛ АЙМАГ/



Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Баяр-Эрдэнэ / Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн дарга/

Гишүүд:

Г.Туул /Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах
мэргэжилтэн/

М.Баярмаа /Төрийн өмчийн бүртгэл,
ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/

Ч.Лхагвадорж /Хууль, эрхзүйн хэлтсийн
мэргэжилтэн/

П.Батдорж /Захиргаа удирдлагын хэлтсийн
жолооч/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 4 дугаар сарын 1 өдрийн
1/2 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг 2022, 2023 оны жилийн эцсийн байдлаар шалган зааварчлах, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит зарим компаниудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, заавар зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйгээр хангахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, орон нутаг дахь зарим төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компаниудын үйл ажиллагаатай танилцах.

Гурав. Хийж гүйцэтгэх ажил

Орон нутагт ажиллахдаа дараах баримт материал, үйл ажиллагаатай биечлэн танилцах, шалгах зааварчлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг хийж гүйцэтгэн, танилцуулга, дүгнэлт, зөвлөмж боловсруулж бэлтгэнэ.

3.1. Орон нутгийн өмчийн газар:

- Байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, 2022, 2023 оны санхүүгийн тайлан, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тайлан;
- Эрх бүхий байгууллагаас батлагдсан орон нутгийн өмчийн харилцааны талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам заавар, аргачлал, бусад баримт бичиг;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн байдал;
- Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хадгалж хамгаалах чиглэлээр гүйцэтгэсэн ажлын тайлан;
- Хөрөнгийн талаар холбогдох байгууллагаас гарах тогтоол шийдвэрийг бэлтгэх танилцуулж, батлуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой баримт материал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн бүрдэл, дүүргэлт, программ ашиглалтын байдал;

- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон компаниудын 2023 оны удирдлага, санхүү, аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн тайлан,
- Өмч хувьчлал, хувьчлалаас гадуур хөрөнгө худалдах асуудлаар бүрдүүлсэн баримт, нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулсан, тайлагнасан байдал;
- Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан “шүгэл, шүүр” ажиллагааг хэрэгжүүлсэн байдал;

3.2. Орон нутгийн өмчит зарим компанид:

Компанийн засаглалын байдалтай танилцах зорилгоор дараах баримтыг бэлтгэнэ.

- Компанийн танилцуулга;
- Компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо;
- Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон шийдвэр, ТУЗ-ийн үйл ажиллагаа (тайлан), ТУЗ-ийн тогтоол, шийдвэр, хурлын тэмдэглэл, тэдгээрийн хууль эрх зүйн үндэслэл, хэрэгжилтийн байдал, цалин хөлс, зардал;
- 2023 оны жилийн эцсийн байдлаарх бизнес төлөвлөгөө, санхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан шийдвэр, түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал;
- Компанид тулгамдаж буй асуудал, санал хүсэлт.

1.3. Төрийн өмчит хуулийн этгээд:


- Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 109 дүгээр тогтоолын дагуу Мэргэжлийн хяналтын газрын үл хөдлөх хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст балансаас балансад шилжүүлэх ажлыг зохион байгуулсан талаарх биелэлт, тайлан;

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ын 4.1-д заасны дагуу Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэх зааварчилгаа өгөх ажлыг зохион байгуулна.

- Орон нутгийн өмчийн газрын төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

-----oOo-----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 4 дугаар сарын 1-ны өдрийн
1/2 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлах, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит зарим компаниудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, заавар зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйгээр хангах албан ажлаар Ажлын хэсгийн албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс 5 дугаар сарын 12-ны өдрүүдэд /хуанлийн 7 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/
1	Хөвсгөл аймаг: Байр: 5 хүн x 7 хоног x 90,000 =3,150,000.00 Хоол: 5 хүн x 7 хоног x 28,000 =980,000.00 Унаа: 820 км x 3590 x 0.19 x = 559,322.00 820 км x 3710 x 0.19 x = 578,018.00	5,267,340.00
	Нийт дүн:	5,267,340.00

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалыг үндэслэв.

Хянасан: Н.Ганболд /Захиргаа удирдлагын хэлтсийн дарга/
Д.Отгонтуяа /Ерөнхий нягтлан бодогч/
Боловсруулсан: М.Баярмаа /ТӨБАХ-ийн мэргэжилтэн/

Шалган зааварчлах ажиллагаанд зориулан
урьдчилан бэлтгэх материалын жагсаалт
(Цаасан болон цахимаар)

Орон нутгийн өмчийн газар:

- Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, 2022, 2023 оны батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан;

- Эрх бүхий байгууллагаас батлагдсан орон нутгийн өмчийн харилцааны талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журам заавар, аргачлал, бусад баримт бичиг;

- Орон нутгийн өмчийн газрын 2022, 2023 оны ажлын тайлан;

- Ирсэн явсан бичиг;

- А, Б тушаалууд

- Өмчийн асуудлаар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүд,

- Хөрөнгийн талаар холбогдох байгууллагаас гарах тогтоол шийдвэрийг бэлтгэх танилцуулж, батлуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой баримт материал;

- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон компаниудын 2023 оны удирдлага, санхүү, аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн тайлан,

- Өмч хувьчлал, хувьчлалаас гадуур хөрөнгө худалдах асуудлаар бүрдүүлсэн баримт, нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулсан байдал;

- Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан “шүгэл, шүүр” ажиллагааг хэрэгжүүлсэн байдал;

- Иргэд, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, эрхзүйн байдал

Орон нутгийн өмчит зарим компаниуд (байгууллага дээрээ уулзалтын өрөөнд цуглуулж, бэлтгэсэн байх):

- Компанийн танилцуулга;

- Компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо;

- Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон шийдвэр, ТУЗ-ийн үйл ажиллагаа (тайлан), ТУЗ-ийн тогтоол, шийдвэр, хурлын тэмдэглэл, тэдгээрийн хууль эрх зүйн үндэслэл, хэрэгжилтийн байдал, зардал;

- 2023 оны жилийн эцсийн байдлаарх бизнес төлөвлөгөө, санхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан шийдвэр, түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал;

- Компанид тулгамдаж буй асуудал, санал хүсэлт.